

## **ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

### **ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН:**

Зарим хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах тухай, Хүн ам, байшин орон сууц, мал тооллогын дүнгийн талаарх мэдээлэл, 2020 онд ОНХС, АЗС, БОХНСЗ болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Дорнод аймагт хийгдэх хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, Орон нутгийн өмчийн асуудлууд, Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарын цалинг тогтоох тухай асуудлуудыг тус тус хэлэлцэн батлав.

### **БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн Дорнод аймгийн мандатыг хуучин хэвээр нь 3 болгон нэмэгдүүлэх саналаа холбогдох газруудад хүргүүллээ.

“ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ЗӨВЛӨЛ”-ийн хуралдаан боллоо

Дорнод аймгийн төр хувийн хэвшлийн зөвлөл өнөөдөр хуралдаж 2020 онд хийх ажлын төлөвлөгөө, ажиллах журмаа баталлаа.

Төр хувийн хэвшлийн зөвлөл нь Төр, хувийн хэвшлээс тус бүр 10 хүний тэнцүү төлөөлөлтэй байх бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга ахлан ажилладаг юм.

Зөвлөл нь хувийн хэвшлийн тулгамдсан асуудлуудыг төрийн бодлого шийдвэрт тусгуулан хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах зорилготой.

### **Хоёр. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:**

Мэдээллийн технологи дээр тулгуурлан үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор “Дорнод аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан боловсруулах” багийн сонгон шалгаруулах ажлын даалгаврыг гаргаж аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын 2019 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 12 дугаар хуралдаанд танилцуулан, тэргүүний сум, агентлагийг шалгаруулав. Үүнд:

Агентлаг:

- Цагдаагийн газар 1 дүгээр байр,
- Орон нутгийн өмчийн газар, Эрүүл мэндийн газар 2 дугаар байр,
- Боловсрол, соёл, урлагийн газар, Статистикийн хэлтэс 3 дугаар байр,

Сум:

- Халхгол сум 1 дүгээр байр,

- Хөлөнбуйр, Хэрлэн сум 2 дугаар байр,
- Баян-Уул, Булган сум 3 дугаар байр тус тус үнэлэгдсэн байна.

Мөн аймгийн Засаг даргын баталсан “Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын хэсгийн зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж ажиллалаа.

**ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:**

**ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:**

Орон нутгийн нийторлого 27527,2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 26542,9 сая төгрөг, үүнээс татварын орлого 6291,1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 6823,9 сая төгрөгт хүрч 532,9 сая төгрөгөөр давж, татварын бус орлого 21236,1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 20619,9 сая төгрөгт хүрч 616,2 сая төгрөгөөр тасарлаа.

### Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	27,527,205,100.00	27,198,958,154.35	(328,246,945.65)	98.81
003 ТАТВАРЫН ОРЛОГО	6,291,071,400.00	6,823,995,451.70	532,924,051.70	108.47
004 Орлогын албан татвар	3,861,890,100.00	4,584,951,443.29	723,061,343.29	118.72
016 Хөрөнгийн албан татвар	296,903,600.00	397,738,660.43	100,835,060.43	133.96
021 Бусад татвар, төлбөр, хураамж	2,076,900,000.00	1,929,669,076.00	(147,230,924.00)	92.91
041 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,236,133,700.00	20,619,896,523.88	(616,237,176.12)	97.10
042 Нийтлэг татварын бус орлого	788,073,000.00	500,082,769.53	(287,990,230.47)	63.46
049 Хөрөнгийн орлого	0.00	24,231,760.00	24,231,760.00	#DIV/0!
056 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	15,851,004,800.00	15,461,193,045.00	(389,811,755.00)	97.5
058 Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	14,226,160,300.00	14,226,160,300.00	-	
059 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,624,844,500.00	1,235,032,745.00	(389,811,755.00)	76.0

#### ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 28843,8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 22020,9 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58,5%
- ✓ Тогтмол зардалд 18,3%

- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%
- ✓ Хөрөнгийн зардалд 13,4% байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 2985,3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 14859,4 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ.

### Орон нутгийн төсвийн нийт зарлага

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,843,806,000.00	22,020,908,520.56	(6,822,897,479.44)	76.3
Цалинхөлсболоннэмэгдэлурамшил	14,561,385,600.00	11,803,385,860.22	(2,757,999,739.78)	81.1
Ажилолгогчооснийгмийндаатгалдтө лөхшимтгэл	1,909,756,000.00	1,352,342,180.04	(557,413,819.96)	70.8
Бараа үйлчилгээний бусад зардал	2,067,212,100.00	1,197,527,356.20	(869,684,743.80)	57.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,269,610,400.00	919,861,148.68	(349,749,251.32)	72.5
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,288,701,400.00	1,490,885,639.00	(3,797,815,761.00)	28.2

### Дөрөв. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж, аймгийн Засаг даргын 231 захирамжид виз өгч, 1 сумын Засаг даргын 53 захирамж, сумын Засаг даргын Тамгын газрын даргын 8 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянан гарсан зөрчил, дутагдалд албан бичгээр зөвлөмж хүргүүлээд байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 6 өргөдөл ирүүлснээс 4 өргөдөл гомдлыг шийдвэрлэн холбогдох хариуг иргэдэд өгч ажилласан. аймгийн Засаг даргад хандан мөнгөн тусламж хүссэн 7 иргэнд 1.400.000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгуулах ажлыг зохион байгуулаад байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/192 дугаар захирамжаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Дорнод аймагт зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2018-2020 онд хийх үйл ажиллагааны дэд хөтөлбөрийн хүрээнд иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих, хэрэг, зөрчлийг таслан зогсоох, бууруулахад төр, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Согтуу жолоочтой хамтдаа тэмцье-2020” нэгдсэн арга хэмжээг 2020 оны 03 дугаар сарын 30-аас 04 дүгээр сарын 30-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Дээрх захирамжийн хүрээнд Аймгийн Цагдаагийн газраас давхардсан тоогоор 53 байгууллага, үйлдвэрлэлийн бааз, 500 гаруй иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангахтай холбогдуулан хууль, дүрмийн сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдалд хяналт шалгалтыг зохион байгуулж, тээврийн хэрэгслийн техникийн аюулгүй байдлыг хангаагүй албан байгууллага, үйлдвэрт албан мэдэгдэл хүргүүлэн ажилласан байна.

Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Малын хулгайн шийдвэрлэлт-2020” нэгдсэн арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020 оны А/193 дугаар захирамжаар 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж ажиллалаа.

**Архивын чиглэлээр:** Аймгийн Архивын тасаг нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шат /2017-2020/-нд гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. Албан хэрэг хөтлөлт, хууль тогтоомж, шийдвэрийн талаар:

Архивын тасагт 2020 оны 4 дүгээр сарын 30-ний байдлаар ирсэн 5 албан бичгийг авч бүртгэн, гадагш 5 тодорхойлолт, 6 албан бичиг боловсруулж явуулсан байна. 1 хариутай бичгийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

2. Баримт ашиглалтын талаар:

4 дүгээр сард 15 байгууллага, 166 иргэнээс лавлагаа мэдээллийн захиалга хүлээн авч 519 хуулбар, 23 тодорхойлолт, 24 иргэнд 151 оны малын А данс гаргаж нийт 2 423 000 төгрөгийн орлого оруулав. Хадгаламжийн сангаас 36 хөмрөгийн 147 хадгаламжийн нэгжийг гаргаж ашиглан бүртгэж буцаан байрлуулав.

Аймгийн Музейн хүсэлтийн дагуу Гэгээрлийн хэлтсийн 1980-1990 оны 36 хадгаламжийн нэгжийг судалгаанд ашиглуулж холбогдох зааврын дагуу баримт дагуу бүртгэл үйлдлээ.



Баяндун сумын Хүүхдийн цэцэрлэг, Булган сумын Хүүхдийн цэцэрлэг, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн архив, бичиг хэргийн ажилтнуудад төрийн архивт шилжүүлэх баримтын талаар заавар зөвлөлгөө өгөв.

## 6.Бусад

2020 оны 4 дүгээр сард Халх гол сумын Ялалт багийн спорт заал, Матад сумын сургуулийн дотуур байрны ариун цэврийн байгууламж, Хөлөнбуйр сумын сургуулийн хичээлийн Б байрны гадна засвар, Булган,Сэргэлэн, Чойбалсан сумдын цэцэрлэг, сургууль, соёлын төвийн халаалтын тогоо шинэчлэх ажил хүлээн авах комисст орж ажилллан заавар зөвлөгөө өгч ажиллав.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2020 оны 9 дүгээр тогтоолын хүрээнд Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн 2016, 2017 оны саналын хуудасыг аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан ажлын хэсэг 4 сарын 29-30-ны өдрүүдэд зөөж устгал хийв.

Хөмрөг 125 буюу цуглуулга хөмрөгийн бүртгэлд 1548-1706 дугаар бүхий 158 ХН бүртгэн, дугаар өгч, хайрцаглан хадгаламжийн санд байрлууллаа.

Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ үйлчилгээг 4 дүгээр сарын 9, 16,24,30-ний өдрүүдэд, чийг дулааны хэмжилтийн бүртгэлийг 4 дүгээр сарын 8,17,29-ны өдрүүдэд хөтөлж ажиллаа.

### **Тав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД: Нэг. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар**

Аймгийн Онцгой комиссын 2020 оны 23 дугаар хурлаас өгөгдсөн үүрэг, чиглэл, Хэрлэн сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/210 дугаар албан тоотын дагуу аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын 17 албан хаагч нараас 15 ажилтан хамрагдаж, Хэрлэн гол дагуу хуваариар хариуцуулсан ногоон бүсийн хог хаягдлыг бүрэн цэвэрлэв. Аймгийн Засаг даргын 2020 оны А/180 дугаар захирамжийн дагуу албан байгууллагын орчин тойрныхоо нийтийн эзэмшлийн зам, талбай, байууллагын доторх, гаднах цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг нийт 4 удаа зохион байгуулав.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/218 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулж, 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй 1 албан хаагчийг 2020 оны 04 дүгээр

сарын 30-ны өдрийг хүртэл цалинтай чөлөөг олгож, гэрээс ажиллах нөхцөл боломжоор хангав.

Дэлхий нийтэд тархаад байгаа цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Онцгой комиссын 2020 оны 9 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/226 дугаар захирамж, аймгийн Засаг даргын баталсан “Эргүүл хяналт” удирдамжийг хэрэгжүүлэх хүрээнд 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн Хэрлэн сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт аймгийн “Эргүүл хяналт” ажлыг зохион байгуулж ажиллав.

Эргүүл хяналтыг тухайн багийн нийтийн эзэмшлийн гудамж, байшингуудын гаднах 4 тоглоомын талбай, 10 дэлгүүр, 4 худаг, Бунхан толгой, Хэрлэн голын эрэг дагуу иргэд олноор бөөгнөрөл үүсч болох газруудад хуваарийн дагуу 10:00-20:00 цагийн хооронд нийт 14 удаагийн хяналт эргүүлийг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран хуваарийн дагуу зохион байгуулж, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газраас гаргасан зөвлөмжийг 400 ширхэгийг тарааж, танилцуулж, 448 хүн маскгүй зүүгээгүй явж байснаас 196 хүүхэд амны хаалт зүүхэд хяналт тавьж ажиллав.



**Хоёр. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Боловсрол, соёл, урлагийн газар**

**Салбарын хэмжээнд хийгдсэн хөрөнгө оруулалт:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр аймгийн Музей, Ялалт музей, найман сумын Соёлын төвийн “Орон нутаг судлах танхим”-ын үзмэр, үзүүллэгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор нэн шаардлагатай 19 нэр төрлийн /сум тус бүрт/ нийт 54,1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг аймгийн Засаг даргын 2020 оны А/248 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт гүйцэтгэгч “Талын анирхуй” ХХК 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүлээлгэн өгөв.

Халхгол сумын Ялалт багийн Ерөнхий боловсролын сургууль нь аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 670,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар спорт заалтай болж байна. Тус сургууль анх 1926 онд байгуулагдсан бөгөөд 94 жилийн дараа шинэ спорт заалтай болж байна. Гүйцэтгэгчээр ажилласан “Эм Эм Си Эйч”-ХХК гэрээний хугацаанаас өмнө барилгыг дуусгаж, ашиглалтад хүлээн авч байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд 2020 оны аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баянтүмэн, Баяндун, Баян-Уул сумын Соёлын төв, Төв номын сан /хүүхдийн уншлагын танхим/, Үлээвэр хөгжмийн дугуйланд нийт 45,0 сая төгрөгийн өртөг бүхий шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газарт хүлээлгэж өглөө.

Аймгийн 2020 оны орон нутгийн хөгжлийн сангийн 30,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөгжимт драмын театрын бага танхимын тохижилт, шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажил хийгдэв.

Аймгийн хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд нийт 775 сурагч 12 дугаар анги төгсөнө. Шинэ төрлийн корона вируст /covid-19/ халдвар тархах эрсдлээс урьдчилан сэргийлж, нийтийн эрх ашгийг хамгаалах, сурагчдыг сургууль төгсөх болон их дээд сургуульд элсэх элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2020 оны А/190 дүгээр захирамжийн хүрээнд Мобиком корпорацийн Дорнод салбарт санал хүргүүлсний дагуу жилийн турш сар бүр 9 Gb-ийн дата эрх бүхий сим картыг 2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газарт Ерөнхий боловсролын сургуулиудын анги удирдсан багш нарт хүлээлгэн өгөв.

Аймгийн Төв номын санд аймгийн 2020 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэн “Эрдэм шинжилгээний танхим”-ын тоног төхөөрөмж, барааг “Гантэлмэн” ХХК, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 25,0 сая төгрөгөөр “Аймгийн төв номын сангийн уншлагын танхимын засвар”-ын ажлыг “Нью вест хаус” ХХК тус тус хийж гүйцэтгэн хүлээлгэж өглөө.

### ***Олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа:***

Шинэ төрлийн корона вирус /COVID-19/-ийн цар тахлын халдвар дэлхий нийтэд тархсантай холбоотой Улсын Онцгой комиссоос сургууль, цэцэрлэгт тогтоосон хорио цээрийг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгасан шийдвэрийн дагуу хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газраас нэгдсэн удирдлагаар ханган “Эргүүл хяналт”-ийн ажлыг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын 27 сургууль дахь хүүхэд хамгааллын баг, баг хорооны нийгмийн ажилтан, холбогдох байгууллагууд, эцэг эхчүүдтэй хамтран зохион байгуулав.

Шинэ төрлийн корона вирус /COVID-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Онцгой комиссын шийдвэр, аймгийн Засаг даргын 2020 оны А/266 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газар, Хөгжимт драмын театр, Хэрлэн сумын 9 дүгээр багт үйл ажиллагаа явуулдаг сургууль, цэцэрлэгийн хамт олон 2020 оны 04 дүгээр сарын 16-30-ны өдрүүдэд батлагдсан хуваарийн дагуу тус багт “Эргүүл хяналт”-ыг хийсэн.

### ***Гурав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар***

#### ***“Өргөдөл, гомдол”-ын шийдвэрлэлтийн мэдээлэл:***

Тайлант сард хүүхэд, гэр бүлийн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол, хүсэлт, хүүхдийн тусламжийн 108 утсаар нийт 6 дуудлага, 2 өргөдлийг хүлээн авч, хуулийн дагуу хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж, 50 хувийн шийдвэрлэлттэй байна. “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө”-гөөр энэ сард нийт 15 хүүхэд, иргэн давтамжтай зөвлөгөө, үйлчилгээ авсан. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д энэ сард гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 2 насанд хүрэгч, 7 хүүхдийг хүлээн авч, 2-30 хоногийн хугацаатай байршуулж, аюулгүй байдалд хяналт тавин, эрүүл мэнд, сэтгэлзүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг үзүүлэн харьяа хамтарсан багт шилжүүлж, үйлчлүүлэгчтэй ажиллах кейс төлөвлөгөө боловсруулан хариу үйлчилгээ үзүүлж байна.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч 2 хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны төлөөлөгчөөр оролцож, хүүхдийг эрүүл мэндийн

үйлчилгээнд хамруулан, нэг цэгт байрлуулан үйлчилгээ үзүүлэхээс гадна насанд хүрээгүй хохирогч 5 хүүхдийн мөрдөн байцаалтад сурган хүмүүжүүлэгчээр оролцож, хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Үрчлэлтийн дүгнэлт хийгдэхээр ирүүлсэн 2 өрхийн нөхцөл байдлыг судлан дүгнэлтийг гарган Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

***Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:***

Корона вируст /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Чойбалсан хөгжил” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай хамтран аймгийн төвд байрлаж буй хүүхдийн тоглоомын талбай, спорт талбай “Анна хоме асрамж, халамжийн төв”-ийг ариутгах зорилгоор Хэрлэн сумын 6 багийн 18 хүүхдийн тоглоомын талбай /9000 м2/ буюу 2 спортын талбай /1600 М2/ талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэв.

Аймгийн Онцгой комисс, аймгийн Засаг даргын 2020 оны А/226 дугаар захирамжийн дагуу аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчидтай хамтран “Эргүүл хяналт”-ын арга хэмжээг Хэрлэн сумын 10 дугаар багийн нутаг дэвсгэрт 12 өдрийн турш 10:00-20:00 цагийн хооронд зохион байгуулсан.

Уг арга хэмжээгээр хүүхдийн тоглоомын талбай болон хүмүүс олноор цуглардаг үйлчилгээний газруудад хяналт тавьж, иргэдэд корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэж, амны хаалтыг тогтмол зүүж хэвшихийг уриалан давхардсан тоогоор нийт 1200 хүүхэд, 1600 гаруй насанд хүрэгчдэд зөвлөмж, шаардлагыг хүргэж, 300 гаруй хүүхдийг эцэг эхэд нь хүлээлгэн өгсөн.

Корона вируст /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас олгосон 2700 ширхэг амны хаалтыг баг, сумын ажлын албатай хамтран зорилтот бүлгийн 400 өрхөд хүргүүлсэн. Мөн гэр бүлийн боловсрол олгох цуврал сургалтын агуулгыг багтаасан гарын авлагыг 245 ширхэгийг бэлтгэж, олшруулан өрхүүдэд хүргээд байна.

Корона вирусын халдвар Дэлхий нийтээр тархаж, хөл хорионд байгаа өдрүүдэд “Хүүхэд, багачуудыг өөрийгөө болон бусдыгаа хамгаалах арга барилд хэрхэн суралцаж байгаа талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжих” зорилгоор “Корона вирусаас өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах вэ” цахим гар зургийн уралдааныг зохион байгуулав. Уралдаанд 3 насны ангилалд нийт 350 гаруй хүүхэд оролцож, өөрсдийн бүтээлээ ирүүлснийг цахим орчинд байршуулж, урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан нас, насны ангилалд 1 хүүхдийг шалгаруулан урамшуулав.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Хүний эрхийг хамгаалагчдыг чадавхжуулах нь” онлайн сургалтыг зохион байгуулж, Хэрлэн сумын баг, сургуулийн 24 нийгмийн ажилтнуудыг хамруулж, чадавхжуулсан. Мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд,

залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан Корона вирустэй холбоотой хүүхэд, иргэдэд “Нийгэм, сэтгэл зүйн тусламж үзүүлэх нь”, Онцгой байдлын үед сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх” сэдэвт 2 удаагийн онлайн сургалтад 2 мэргэжилтэн, “Хүний эрхийн хамгаалагч” 1, өдрийн онлайн сургалтад 3 мэргэжилтэн тус тус хамрагдав.

Зан үйлийн албадан сургалтыг зохион байгуулах төлөвлөгөөний дагуу гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн шүүхээс зөрчлийн арга хэмжээ авсан болон бусад зөрчлөөр цагдан хоригдож буй 77 иргэнд “Стрессээ зохицуулах, өөртөө итгэх итгэл, хүүхэд хүмүүжлийн эерэг арга” зэрэг сэдвээр 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.

### ***Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:***

Залуучууд хөгжлийн төвөөс “Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт”-ыг цувралаар өсвөр үе, залуучууддаа тогтмол зохион байгуулж байна. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байранд хоригдож байгаа, Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны хүүхдүүд, аж ахуй үйлчилгээнд ажиллаж хорих ял эдэлж байгаа хоригдол, Цагдаагийн газрын эрүүлжүүлэх саатуулах байрны баривчлах байранд хүмүүжиж байгаа нийт 87 хүнд “Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах”, “Стрессээ хэрхэн зохицуулах вэ” сэдвээр 4 удаагийн сургалтыг зохион байгуулав. Мөн Гадаадын иргэн харьяатын газрын зүүн бүс дэх газарын 15 албан хаагчдад “Байгууллагын хамт олны харилцаа” сэдвээр сургалтыг зохион байгуулав.

Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 3 залуучуудад “Хүрч очих үйлчилгээ”-г үзүүлж, амьдрах ухааны чадвар олгох, хувь хүний хөгжлийг дэмжих цуврал сургалтыг зохион байгуулж байна.

“Залуучууд коронавирусын эсрэг нэгдэж байна” аянд “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ нэгдэн 250 ширхэг маск хандивласныг иргэд нийтэд түгээж, 500 гаруй иргэдэд зөвлөмж мэдээллийг хүргэсэн.

### ***Хэвлэл мэдээллийн хүрээнд:***

Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөөг түшиглэн “Сэтгэл зүйн боловсролыг хүн бүрт” олгох зорилтыг дэвшүүлэн хөл хориотой байгаа энэ хугацаанд цахим орчинд иргэдэд хүртээмжтэй, зөв мэдээллийг түгээх зорилгоор “Сэтгэл зүйч зөвлөж байна” цуврал подкастыг хүргэж байгаа билээ. Тайлант сард “Хүүхдийн нас сэтгэхүйн онцлог” “Хосуудын харилцаа” сэдвээр 2 удаагийн дугаараар нийт 3000 гаруй хүнд мэдээллийг түгээсэн.

Мөн энэ сард гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр нийт 23 мэдээллийг “Гэр бүл, хүүхэд, Дорнод фэйсбүүк хуудас”, [www.dornodzaluus.mn](http://www.dornodzaluus.mn) веб сайт, гар утасны аппликейшинд байршуулснаар мэдээлэл хүлээн авсан нийт үзэгчдийн тоо 735 хүн, нийтлэл хуваалцсан 580 байна.

Мөн хөл хорионы хугацаанд “Хүүхэд багачуудад зөв хүмүүжил төлөвшил олгох, зөв үлгэр дуурайлал үзүүлэх” зорилгоор хүүхдийг үлгэрээр хүмүүжүүлэх хүмүүжлийн эерэг аргыг сурталчлах хүрээнд “Үлгэрийн цаг”-ийг бэлтгэн 3 удаагийн дугаарыг давхардсан тоогоор 1500 гаруй хүнд хүргэсэн.

### **Бусад ажлын хүрээнд:**

Аймгийн Онцгой комиссын “Шуурхай штаб”-ын жижүүрт 2 мэргэжилтэн хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж, иргэд олон нийтийг мэдээллээр хангаж ажиллаж байна. Мөн корона вируст /COVID-19/ халдварын тохиолдол Монгол Улсад бүртгэгдсэнтэй холбогдуулан цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажил зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/180 дугаар захирамжийн дагуу 20 албан хаагч “Хэрлэн голын орчинг” цэвэрлэх их цэвэрлэгээний ажилд оролцож, их цэвэрлэгээнд нэгдсэн.

### **Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс**

#### **Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:**

2020 оны 4 дүгээр сард 3431814,7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1812323,39 мянган төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг өссөн дүнгээр 91,60 хувиар биелүүлсэн байна.

2020 оны 4 дүгээр сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Нийгмийг даатгалыг сангийн орлого /мянган төгрөг/

д/д	Төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Тэтгэврийн даатгалын санд	2004778,6	1145773,5	57,1
2	Тэтгэмжийн даатгалын санд	196221,5	130982,34	66,7
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд	174354,5	131971,6	75,6
4	Ажилгүйдлийн даатгалын санд	35575,7	28760,1	80,8
5	Эрүүл мэндийн даатгалын сан	1020884,4	374835,7	36,7
	Нийт	3431814,7	1812323,24	52,8

Засгийн газрын 2020 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шимтгэлийн орлогын төлөвлөгөө буурсан үзүүлэлттэй байна.

#### **2. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:**

2020 оны 4 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 647072.2 мянган төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 82,1 хувь буюу 530891.9 мянган төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага, 17,9 хувь буюу 116180.3 мянган төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна. Нийт авлагын 39,8 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.

### **3. Нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх өөрчлөлтүүдийн хэрэгжилтийн талаар:**

1. Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчид тэтгэврийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх талаар:

Уг хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан журам, зааврын дагуу аймгийн хэмжээнд 2020 оны 4 дүгээр сард 23 иргэний 45318,0 мянган төгрөгийн шимтгэлийг тэтгэврийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

2. Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн тоогоор 1 жил 6 сар нэмж тооцдог болсон талаар:

Аймгийн хэмжээнд 2020 оны 3 дугаар сард нийт 143 иргэнд шинээр тэтгэвэр тогтоосон. Үүнээс:

Өндөр насны тэтгэвэр 98, (хэвийн 43, хувь тэнцсэн 28, малчин 11, хүүхдээр 48, хүнд нөхцөл 6, цэргийн алба хаасан 7)

Тахир дутуугийн тэтгэвэр 39,

Тэжээгч алдсаны тэтгэвэр 6,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5-д зааснаар төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор 1 жил 6 сарыг ажилласан хугацаанд тооцох заалт хэрэгжиж эхэлснээр энэ сард өндөр насны тэтгэвэр тогтоолгосон нийт иргэдийн 40,1%-г эзэлж байна.

### **4. Хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхийн шимтгэл төлөлт тасрахгүй байх нөхцөл бүрдсэн талаар:**

Нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсны тэтгэмж авах эрх үүссэн эх хүүхдээ 3 нас хүртэл нь асарч байх хугацаанд сард төлбөл шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд, 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас төлөх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараахь арга хэмжээг авч ажиллав. Тэтгэмжийн сангаас 445 даатгуулагчийн шимтгэл болох нийт 26140,2 мянган төгрөгийг тэтгэврийн санд 239803.6, тэтгэмжийн санд 2085,3 мянган төгрөгийн эхийн шимтгэлийг шилжүүлсэн болно.

### **5. Сайн дурын даатгуулагч эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 100 хувиар тооцож олгох талаар:**

Уг хуулийн үйлчлэлд хамрагдсан 43 даатгуулагч эхэд 26700,0 мянган төгрөг олгосон бөгөөд үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8000,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

#### **6.Эмнэлэг хөдөлмөрийн магадлал:**

Шинэ корона вируст халвар (COVID-19) гарсантай холбогдуулан иргэдийг олноор цуглуулахгүй байх шийдвэр гарсантай холбогдуулан Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс цахим хурлаар 4 удаа хуралдаж, 281 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 40 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан, 190 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан, 51 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна.

Цуцлагдсан 40 иргэний 25 нь өндөр насны тэтгэвэр тогтоолсон, 9 нь заалтын хугацаа дууссан, 6 нь эмчлэн эрүүлжсэн иргэд байна.

#### **7. Архивын үйлчилгээний талаар:**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2011 оны 32 дугаар тушаалын дагуу хадгаламжийн нэгжийн эх хувь болон нийгмийн даатгалын мэдээллийн цахим сангаас архивын лавлагааг 88 иргэнээс хүсэлт ирж, 50 иргэнд 166 оны баримтаас 49,000 төгрөгийн төлбөртэй лавлагаа, 7 аймаг, дүүргийн хооронд 16 иргэнд 27 оны лавлагааг олгосон.

#### **Тав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар**

#### **Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ**

#### **Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ:**

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, их, дээд болон мэргэжилийн боловсролын сургууль төгссөн 47 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгснөөс хөдөлмөрт бэлтгэх зөвлөгөө 26, хөдөлмөр эрхлэлтийн талаар 17 иргэн, мэргэжлийн талаар 4 иргэнд зөвлөгөө өгөөд байна. Зөвлөгөө мэдээлэлд хамрагдсан иргэдийг насны ангиллаар авч үзвэл 15-24 насны 12 иргэн, 25-34 насны 7 иргэн, 35-44 насны 19 иргэн, 45-54 насны 8 иргэн, 60-аас дээш насны 1 иргэн тус тус хамрагдсан байна.

#### **Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэний мэдээ:**

Тайлант сард 21 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс 104 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу 896 иргэнд цахим хуудас болон хэвлэмэл хуудсаар иргэдэд санал болгож, 96 иргэнийг байнгын ажлын байранд зуучлаад байна.

Эдийн засгийн салбараар авч үзвэл хөдөө аж ахуй 52, уул уурхай 7, боловсруулах 14, бөөний болон жижиглэн худалдаа 4, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 4, төрийн байгууллага 2, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 13 иргэн тус тус зуучлагдсан байна.

### ***Бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ***

Тухайн сард 1632 ажил хайгч иргэн бүртгэлтэй байна. Үүнээс 54 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 16,5 хувийг тусгай, техникийн боловсролтой иргэд, 0,6 хувийг суурь боловсролтой иргэд, 16 хувийг дээд боловсролтой иргэд эзэлж байна.

2019 онд “Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэх SECiM төсөл”-тэй хамтран хэрэгжүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн туршилтын шинэ арга хэмжээнүүдийн үр дүнг тодорхойлох судалгааг Хэрлэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 151 аж ахуй нэгж байгууллага, 248 иргэн, нийт 399 судалгааг төсөл рүү хүргүүлээд байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20,2 дах заалтын дагуу аж ахуй нэгж байгууллагаас сул чөлөөтэй 24 ажлын байрны захиалга, шинээр ажилд авсан 34 иргэний мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж мэдээллээд байна.

### ***Шинэ ажлын байр***

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 1248 иргэнээс түр ажлын байранд 41 иргэн, байнгын ажлын байранд 96 иргэн тус тус зуучлагдсан байна.

### ***Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр***

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-үүдийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлд танилцуулан 2020 онд хэрэгжих үйл ажиллагааны салбар, чиглэлийг батлуулсан. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн танилцуулга болон мэдээллийг бэлтгэж, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс 4 дүгээр сарын 17-ны хүртэл төсөл хүлээн авах, ил тод, нээлттэй зохион байгуулах чиглэлээр аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын цахим хуудсаар болон “ТВ-6”, “Jaran.mn”, “FM 86.1”, “Мижи” телевизүүдтэй хамтран ажиллаж иргэдэд хүртээмжтэй байдлаар шторк, хөтөлбөрийн таницуулга мэдээллийг хүргэж, 4 сарын 25-аас нөхцөл байдлын үнэлгээ хийж ажиллав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй нийт 106 иргэн, ажлын байргы дэмжих хөтөлбөрт 102 иргэн, ахмад настны ажлын байрыг дэмжих эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 41 иргэний төсөл, хөтөлбөр, материалыг хүлээн авч ажлын хэсэг нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд “Дорнод Ган хийц” ХХК, “Дүнзка” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

### **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

Нийгмийн халамжийн тэтгэвэр 1886 иргэн хамрагдаж, 341,9 сая төгрөг, асаргааны тэтгэмжид 1384 иргэнд 123,7 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 295 иргэнд 58,4 сая төгрөг, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмжид 4787 иргэнд 223,5 сая төгрөг, ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлтөд 288 иргэнд 41,1 сая төгрөг, алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлтийг 27 ахмад настанд 4,1 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтийг 267 иргэнд 12,0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, хүүхдийн мөнгөний талаар:**

Тухайн сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 14 сумын 2339 өрхийн 6935 том хүн, 6038 хүүхдэд нийт 12973 хүнд хүргэж, 159,264.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Корона вирус /КОВИД-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу улс орон даяар зарлагдсан “Маскаа зүүцгээе” аяны хүрээнд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газартай хамтран хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ олгодог 71 хүнсний дэлгүүрээр дамжуулан аймгийн хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 2239 өрхийн нийт 12373 иргэнд амны хаалт тараах ажлыг зохион байгуулсан. Мөн Хэрлэн сумын 11 багийн зорилтот бүлгийн 100 өрхийн 600 гаруй иргэдийн гэрээр нь зочилж амны хаалт олгосон.

### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр:**

Аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал”-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан холбогдох газруудад хүргүүлээд байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс” энэ сард 1 удаа хуралдаж, 9 хүүхдийн асуудлыг хэлэлцэн 5 хүүхдийн байнгын асаргааг шинээр тогтоож, 1 хүүхдийн байнгын асаргааг цуцалж, 2 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлон, 1 хүүхдийн байнгын асаргааг сунгав. Мөн 6 хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд, 8 хүүхдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучлаад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих аймгийн салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

***Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ:***

**Зөвлөгөө өгөх үйлчилгээ:**

“Аминчлахуй” Төрийн бус байгууллага согтуурах, мансуурах донтой иргэдэд ганцаарчилсан амьдралын итгэл үнэмшил олгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, архины хор хөнөөлийн талаар насанд хүрэгчийн сэтгэл зүйн зөвлөгөө, гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө гэх зэрэг сургалтын хөтөлбөрийн дагуу зөвлөгөө өгөх үйлчилгээг зохион байгуулсан.

Зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсанаар зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн идэвхи сайжирч, өөрийгөө илэрхийлэх чадвар нэмэгдсэн. Архи болон тамхины хор хөнөөлийн тухай шинжлэх ухааны үндэслэлтэй илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй болж, архи, тамхинаас татгалзах эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэх, бусдыг уриалан дуудах дадал эзэмшиж байна. Тайлант хугацаанд архины хамааралтай 15 иргэн үйлчилгээнд хамрагдаж 1,650,000 төгрөгийг зарцуулсан.

**Бүлгийн төсөл:**

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зорилгоор 7 бүлгийн төслийн явцтай танилцаж, нөхцөл байдлыг үнэлж, дүгнэн 7 бүлгийн төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлж 10,000,000 төгрөгийг зарцуулсан.

Бүлгийн төслийг үйл ажиллагааны чиглэлээр харуулбал:

- Ногоо, жимс жимсгэнэ 2 бүлэг 2,500,000 төгрөг,
- Гахайны аж ахуй 1 бүлэгт 1,500,000 төгрөг,
- Тахианы аж ахуй 1 бүлэгт 1,500,000 төгрөг,
- Үйлчилгээ /бусад/ 3 бүлэгт 4,500,000 төгрөг

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд Ахмадын эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авахаар хүсэлт гаргасан 30 иргэний үйл ажиллагаанд нөхцөл байдлын үнэлгээ хийж байна. Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг нь иргэний үйл ажиллагаа явуулж буй ажлын байртай нэг бүрчлэн танилцаж, дүгнэлт гаргасан.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас санаачлан зорилтот бүлгийн өрхийн гишүүдэд чиглэсэн шинэ корона вирус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг Хэрлэн сумын 11 багийн Засаг даргын Ажлын албатай хамтран 2020 оны 04 дүгээр сарын 6-8-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Тус ажлын хүрээнд “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэлтэй амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой Хэрлэн сумын 11 багийн 100 өрхийн 4-18 насны 300 хүүхэд, 19-81 насны 200 иргэн буюу нийт 500 иргэнд халдвараас урьдчилан сэргийлэх, олон удаа хэрэглэх амны хаалт, орчны ариун цэвэр, аюулгүй байдлыг хангах, гар угаах, хоол, хүнсний зохистой хэрэглээний зөвлөмж, гарын авлага, хүүхэд, ахмад настны дархлааг дэмжих чацарганаас бүрдсэн “багц”-ыг хүргэсэн.

Мөн аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Боловсрол, соёл урлагийн газрын удирдлагууд өрхөөр зочлон шинэ корона вирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, зайны сургалтын чанар, үр дүн хэрэгжилтийн явцтай танилцсан бөгөөд иргэд мэдээ, мэдээлэл сайн байгаа ч гэрийн нөхцөлд урьдчилан сэргийлэх шат дараатай арга хэмжээ аваагүй, хүүхдийн амны хаалт, давс, содын уусмалын хангалт дутмаг, 00-ын ариун цэвэр, гараа зөв угаах дадал хангалтгүй байсан.

Аймгийн Онцгой комиссийн шийдвэрийн дагуу зорилтот бүлгийн иргэдэд амны хаалт тараах ажилд оролцсон.

Шинэ корона вирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Онцгой комиссийн шийдвэрийн дагуу Хэрлэн сумын 11 багийн зорилтот бүлгийн 1742 өрхийн 9665 иргэнд амны хаалтыг өгөх ажлыг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулсан.

### ***Зургаа. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар***

#### ***COVID-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:***

Нийгмийн эрүүл мэндийн төвөөс COVID-19 урьдчилан сэргийлэх 7 төрлийн 5750 ширхэг зөвлөмж ирснийг бүх анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, Хэрлэн суманд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, орон сууцны орц, үйлчилгээний байгууллагуудад байршуулан, иргэдэд түгээв. Нийт 304 орц, 35 байгууллага, 24 эмийн сан, 5 худалдааны зах, 400 гаруй аж ахуй нэгж, үйлчилгээний газрууд, 1850 иргэдэд түгээж, 85 хувьтай байна.

Хэрлэн сумын 11 баг болон 13 сумдад Корона вируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгаа зөвлөмж, сэрэмжлүүлэгийг бичлэг хийн хүргүүлэн дуут дохио, хөдөлгөөнт хэлбэрээр 4 дүгээр сарын 15-30-ны өдрүүдэд үргэлжлүүлэн олон нийтэд түгээн ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/180 дугаар захирамж, Хэрлэн сумын Засаг даргын 2020 оны А/121 дүгээр захирамж, аймгийн Онцгой комиссын 22 дугаар хуралдааны шийдвэрээр Чойбалсан хотын хэмжээнд халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулсан. Чойбалсан хотын хэмжээнд 17447,1 м2 талбайд 345 хайрцаг жавелион, 105 килограмм хайкоп ариутгалын бодисыг хэрэглэсэн.

Улсын Онцгой комиссын шийдвэрээр корона вируст /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх “Маскаа зүүцгээ” аян улс орон даяар зохион байгуулагдаж байна. Аяны хүрээнд корона вируст /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн нийтийн эзэмшлийн гудамж талбай, худалдаа үйлчилгээний төвүүд, хүн амын бөөгнөрөл ихээр үүсдэг Чойбалсан хотын “Найрамдал” цэцэрлэгт хүрээлэн зэрэг газруудад аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Онцгой байдлын газрын албан хаагчидтай хамтран амны хаалтны хэрэглээг хэвшүүлэх, гараа тогтмол ариутгах, бээлий өмсөх зэрэг зөвлөмжийг амны хаалт зүүгээгүй нийт 178 иргэнд өгч ажилласан.

Аймгийн гамшгаас хамгаалах нөөцөд 20000 ширхэг амны хаалт нөөцлөх чиглэлийн дагуу оёх ажлын хэсгийг байгуулж, Хэрлэн сумын сургууль, цэцэрлэгийн багш нараар оёулсан амны хаалтны нөөцөөс аймгийн Хөдөлмөр, халамжийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 12894 иргэнд энгийн амны хаалт түгээх ажлыг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газраас томилогдсон 21 мэргэжилтэн Хэрлэн сумын 11 багийн 9665 иргэнд хүргэсэн ба хөдөөгийн 13 сумын 3319 ширхэг амны хаалтыг харъяа сумын эрүүл мэндийн төвөөр дамжуулан зорилтот бүлгийн иргэдэд хүргэж ажилласан.

Корона вирус (COVID-19) цартахалын үед өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах зорилгоор 2020 оны 04 дүгээр сарын хугацаанд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газартай хамтран олон хүн төвлөрсөн худалдааны байгууллага болох “Шүр” захаар эргүүлд гарч, иргэдэд зөвлөгөө өгч ажиллав.

### ***Хачигт халдвараас сэргийлэх вакцин:***

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд захиалгын дагуу вакцин, дагалдах хэрэгслийг хуваарилсан. Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс 1200 хүн тун хачигт халдвараас сэргийлэх вакцин хүлээн авч голомтот нутгийн иргэд болон аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Онцгой байдлын газар, Мал эмнэлэгийн газрын нийт 600 албан хаагч, иргэнийг хачигт халдвараас сэргийлэх дархлаажуулалтад хамруулсан.

### ***Элэг бүтэн Монгол хөтөлбөр:***

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр зорилтот бүлгийн 31-40 насны 1000 эмэгтэйг элэгний В вирусын вакцинд хамруулах төсөл хэрэгжиж, одоогийн байдлаар нийт 520 эмэгтэйд элэгний В вирусийн вакцины 2 дугаар тунд хамруулаад байна. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн байгууллагын нийт 167 ажиллагсдыг элэгний В вирусийн вакцины 3 дугаар тунд хамруулсан. Хамралт 100 хувьтай байна.

### ***Эрүүл оюутан төсөл:***

Аймгийн Засаг даргийн 2020 оны А/138 дугаар захирамжаар батлагдсан “Эрүүл оюутан” төслийн нээлтийн үйл ажиллагааг 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Дорнод их сургууль дээр зохион байгуулж, төслийг хэрэгжүүлэх Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, хувийн шүдний эмнэлгүүдтэй хамтран ажиллах гэрээг байгууллаа. Төслийн хүрээнд Дорнод Их Сургууль, Политехник коллеж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 1264 оюутныг ерөнхий биеийн үзлэг, чих, хамар хоолой, нүд, БЗДХ, сүрьеэгийн эрт илрүүлэг, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулахаас гадна 1 болон 2 дугаар дамжааны 200 оюутны амны хөндийг бүрэн эрүүлжүүлэх юм.

### ***Нийгмийн эрүүл мэндийн төвийн шинэ барилга:***

Дорнод аймгийн Хэрлэн сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Түүх соёл” ХХК барьж, 2020 оны III улиралд ашиглалтад орох Нийгмийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын шав тавих арга хэмжээг зохион байгуулж, барилгын ажлыг эхлүүлээд байна.

### ***Нийгмийн эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж:***

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 8,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Нийгмийн эрүүл мэндийн төвд шаардлагатай 7 нэр төрлийн 8 тоног төхөөрөмжийг “Мед буян” ХХК нийлүүлж, 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр хүлээлгэн өгсөн.

### ***Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмийг гэрээр хүргэх:***

Аймгийн Онцгой комиссын 2020 оны 28 дугаар хуралдааны шийдвэрээр хөнгөлөлттэй эмээр үйлчлэх эрх бүхий эмийн сангууд ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмийг гэрээр хүргэх үйлчилгээг эхлүүлсэн.

### ***Магадлан итгэмжлэлийн үнэлгээ:***

Эрүүл мэндийн Сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын 6 дахь хэсгийн 6.2 дахь заалтыг үндэслэн магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан Халхгол, Дашбалбар, Баян-Уул сумын Сум дундын эмнэлгүүдэд 2020 оны 04 дүгээр сарын 27-29-ны өдрүүдэд шинжээчдийн баг үнэлгээ хийв.

## **Зургаа. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР**

### **ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн хэмжээнд 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор 14 сумын 67 багийн 5311 малчин өрхөд 2.629.622 толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 5.7 сая толгой мал хаваржиж байна.

**Төл бойжилт:** 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор 2,629,622 толгой мал тоологдсоны 1.190.051 толгой хээлтэгч буюу нийт малын 45.2 хувийг эзлэж байна. Аймгийн хэмжээнд 1,190,051 хээлтэгч малаас 1,029,535 толгой төл мал хүлээж авах төлөвлөгөөтэй байна.

**Төллөсөн хээлтэгч:** 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт хээлтэгчийн 2.3 хувь буюу 23449 толгой мал төллөөд байна.

**Үүнд:** Ингэ 70 толгой буюу 6 хувь, гүү 1143 толгой буюу 1.7 хувь, үнээ 3998 толгой буюу 5,3 хувь, эм хонь 10833 толгой буюу 1,9 хувь, эм ямаа 7405 толгой буюу 2,2 хувь байна. Гарсан төл мал нь нийт 23517 толгой байна. Үүнд: Ботго 70 толгой, унага 1143 толгой, тугал 3998 толгой, хурга 10870 толгой, ишиг 7436 толгой байна.

**Төл малын хорогдол:** Гарсан төлийн 1.2 хувь буюу 296 толгой төл мал хоргодоод байна. Үүнд: унага 11 толгой, тугал 48 толгой, хурга 122 толгой, ишиг 115 толгой төл мал хорогдоод байна.

**Бойжиж буй төл мал:** Аймгийн хэмжээнд 23221 толгой төл мал бойжиж байна. Үүнээс: Ботго 70 толгой, унага 1132 толгой, тугал 3950 толгой, хурга 10748 толгой, ишиг 7321 толгой байна.

**Том малын зүй бус хорогдол:** Аймгийн хэмжээнд нийт малын 0,03 хувь буюу 809 толгой мал зүй бусаар хорогдоод байна. Үүнд: Адуу 50 толгой, Үхэр 148 толгой, Хонь 257 толгой, ямаа 354 толгой мал хорогдсон байна.

**Хорогдсон хээлтүүлэгч мал:** Аймгийн хэмжээнд нийт хорогдсон малын 0.7 хувь буюу 6 толгой хээлтүүлэгч мал хорогдсон байна. Үүнд: Хуц 2 толгой, ухна 4 толгой хорогдсон байна.

**Өвчнөөр хорогдсон мал:** Аймгийн хэмжээнд нийт хорогдсон малын 0,6 хувь буюу 4 толгой мал өвчнөөр хорогдсон байна. Үүнд: Өвчнөөр үхэр 4 толгой хорогдсон байна.

**Цасан бүрхүүл:** Дорнод аймгийн Халхгол сум 50%-ын цасан бүрхүүлтэй, цасны дундаж зузаан 4-6 см байгаа ба бусад сумдын нутгаар цасан бүрхүүлгүй байна.

**Малчдын түвшинд:** Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөмж, аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн

хэмжээнд малчдын түвшинд 86,1 мянган тн хадлан бэлтгэхээс 83,3 мянган тн хадлан бэлтгэж гүйцэтгэл 96,7 хувьтай байна.

**Малчдын түвшинд бэлтгэсэн өвс, тэжээлийн үлдэгдэл:** Малчид 56465,5 тн өвс буюу 65,5 хувь, 174,7 тн буюу 47,8 хувийг зарцуулаад байна.

Аймгийн хэмжээнд 29671 тн өвс буюу 34,4 хувь, 190,3 тн тэжээл буюу 52,1 хувь үлдэгдэлтэй байна.

**Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээл:** 2019-2020 оны Өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор аймаг, сумын аюулгүй нөөцийн өвс, тэжээлийг Аймгийн аюулгүйн нөөц 180 тн өвс бэлтгэхээс 303,8 тн өвс бэлтгэж 168,7 хувь, 40 тн тэжээл бэлтгэхээс 50 тн тэжээл, бэлтгэж 125 хувь бэлтгэсэн.

**Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн үлдэгдэл:** Аймгийн аюулгүй нөөцийн өвс 8,8 тн буюу 2,8 хувь, тэжээл 8,7 тн буюу 17,4 хувийг нь борлуулсан байна. Аймгийн хэмжээнд 295,8 тн өвс буюу 97,1 хувь, 41,3 тэжээл буюу 82,6 хувь нь үлдэгдэлтэй байна.

**Сумын аюулгүй нөөцийн өвс, тэжээл:** Сумын аюулгүйн нөөц 1400 тн өвс бэлтгэхээс 1420.5 тн өвс бэлтгэж 101.4 хувь, 420 тн тэжээл бэлтгэхээс 381.8 тн тэжээл бэлтгэж 90.9 хувьтай, аймгийн хэмжээнд хадлан, тэжээл бэлтгэлийн ажил дунджаар 101.5 хувьтай бэлтгэсэн.

**Сумын аюулгүй нөөцийн өвс, тэжээлийн үлдэгдэл:** Сумын аюулгүй нөөцийн өвс 1070 тн буюу 75,3 хувь, тэжээл 130,9 тн буюу 34,2 хувийг зарцуулаад байна. Сумын аюулгүй нөөцөд 350,5 тн өвс буюу 24,6 хувь, 243,5 тн тэжээл буюу 65,7 хувийн үлдэгдэлтэй байна.

**Сумдад ажилласан тухай:** Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Мал амьтны халдварт өвчин, Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах тухай, захирамж болон албан даалгаврын хэрэгжилтийг хангуулахын зэрэгцээ шинэ коронавирус Covid-19 халдвараас урьдчилан сэргийлэхтэй холбогдуулсан гаргасан аймгийн Засаг даргын 2020 оны А/111, А/124, А/129, А/157 дугаар захирамжийн хэрэгжилтийг сумдад хэрхэн зохион байгуулсан байдалд хяналт тавих, болзошгүй эрсдлийн бэлтгэл, бэлэн байдалтай танилцаж, холбогдох арга зүй зөвлөмжөөр хангах ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбатаар ахлуулсан ажлын хэсэгт аймгийн Засаг даргын Тамгын газрын ХОХБТХ-ийн Байгаль орчин, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн, ОБГазрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ХХААГ-ын Мал үржлийн албаны дарга, мэргэжилтэн нар Цагаан-Овоо, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Чулуунхороот сумдын мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг болон удирдамжинд заасан Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болон аймаг, сумын Засаг даргын захирамж, албан даалгаварын хэрэгжилтийг хангасан эсэх мөн коронавирус Covid-19 халдвараас урьдчилан сэргийлэхтэй холбоотой авч хэрэгжүүлсэн зохион байгуулсан ажлуудад хяналт хийж, заавар, зөвлөмж өгч ажиллалаа.

Өвөлжилт, хаваржилтын цаг үеийн мэдээ, гадны малын шилжилт хөдөлгөөн, Сумын аюулгүйн нөөцийн үлдэгдэл болон зарцуулалт, малчин мал бүхий иргэдээс хөдөө аж ахуйн чиглэлээр судалгаа авч ажиллаа.

Дээрх судалгаанд 6 сумын 92 малчин болон мал бүхий иргэнийг хамруулсан.

**Судалгааны ажлын талаар:** Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн нь “Монголын ноолуурын чиглэлийн ямааны үржлийн ажлын үндэсний хөтөлбөр боловсруулахад чиглэсэн үүлдэрлэг байдлын генетик судалгаа” судалгааны ажлын хүрээнд генетоп үзүүлэлтээр шилэн сонголт явуулж үржлийн хөтөлбөр боловсруулах зорилгоор Цагаан-Овоо сумын 10 малчин өрхийн 150 толгой хар ямаанаас ноолуурын дээж авч, сэрвээний өндөр, биеийн ташуу урт, цээжний бүслүүр, цээжний гүн, цээжний өргөн, шилбэний бүслүүр гэсэн 6 хэмжилт хийж, хаврын амьдын жин, ээмэгжүүлж бүртгэлжүүлэлт хийж ажиллаа. Дээрх ямааг <http://nlis.mofa.gov.mn/nlismanagement/> Малын үндэсний бүртгэл мэдээллийн системд бүртгэх ажил явагдаж байна.

**Малчдад урамшуулал олгсон тухай:** “Тэмээ” дэд хөтөлбөрийн хүрээнд 14 сумын 1126 толгой ботго бойжуулсан 363 малчин, мал бүхий өрхөд 22,5 сая төгрөгийн урамшууллыг Төрийн банкаар дамжуулан малчдад олгож эхэллээ.

Дээрх арга хэмжээг 6 дахь жилдээ зохион байгуулан ажиллаж байна.

## ГАЗАР ТАРИАЛАН:

Тариалангийн талбайг хашаажуулах тухай: Аймгийн хэмжээнд тариалангийн талбайг хашаажуулж, хөрс хамгаалах арга хэмжээ авч ажиллаж буй 5 сумын 17 аж ахуйн нэгжийн 227 км хашааг 2007-2019 оны хооронд байгуулсан судалгааг гарган ажиллаа. Үүнд: Улсын төсвийн 303,7 сая, төгрөгийн хөрөнгө оруулалтаар 45 км хашааг 2019 онд Халхгол сумын 11 аж ахуй нэгж хамрагдсан. Мөн хувийн хэвшлийн 695,0 сая, төгрөгийн хөрөнгө оруулалтаар 182 км хашааг байгуулан ажиллаж байна.

## Төмс, хүнсний ногооны судалгаа:

Д/д	Сумдын нэрс	ААН иргэний нэр	Төмс	Хүнсний ногоо	Хүнсний ногооны төрөл			
					Байцаа	Сонано	Манжин	Лууван
1	Хэрлэн сум	"Дорнод гурил" ХХК	80.0	0.0				
2		"Гантүрүү" ХХК	7.0	4.8	0.8	1.5	1.5	1.0
3		"Модунь шаньюй" ХХК	15.0	0.0				
4		"Дайхар булгийн өгөөж"	2.0	0.0				



		ХХК							
5		"Өргөст ногоон хүлэмж" ХХК	2.0	2.6	0.4	0.4	1.3	0.5	
6		"СЭМБО" ЗБН	4.0	4.8	1.0	1.0	0.3	2.5	
7		"Асгат уул" ХХК	2.0	1.5	1.0		0.3	0.2	
8		"Нутгийн тус" ХХК	0.2	0.0					
9		Тариаланч С.Баттулга	1.2	2.1	0.5	0.4	0.2	1.0	
10		Тариаланч С.Энхтулга	0.0	1.6			0.3	1.3	
11		Тариаланч Д.Ренчинзаяа	0.0	0.6			0.4	0.2	
12		Тариаланч М.Хишигсүрэн	0.5	0.2				0.2	
13	Баяндун сум	Иргэд	30.8	1.0				1.0	
14	Чулуунхороот сум	Иргэд	0.4	0.0					
15	Гурванзагал сум	Иргэд	1.2	0.0					
16	Хөлөнбуйр сум	Иргэд	1.0	0.8	0.3	0.3		0.2	
17	Дашбалбар сум	Иргэд	0.0			0.06	0.03	0.03	
18	Баян-Уул сум	Иргэд	2.1					0.04	
		<b>Нийт дүн</b>	<b>149.4</b>	<b>20.2</b>	<b>4.0</b>	<b>3.7</b>	<b>4.3</b>	<b>8.2</b>	

ХХААХҮ-ийн сайд Аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2020 онд үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалт, уринш боловсруулалтын төлөвлөгөөг сум бүрийн түвшинд хуваарилан хүргүүлэв. Үүнд:

2020 оны төлөвлөгөө	Нийт үр тариа (га-аар)	Үр тариа таримлын төрлөөр (га-аар)				Бусад таримал (га-аар)				Нийт тариалах талбай (га-аар)	Уриншийн төлөвлөгөө (га-аар)
		Буудай	Арвай	Овьёос	Бусад үр тариа	Тосны ургамал	Малын тэжээл	Төмс	Хүнсний ногоо		
Тариалах талбай (га-аар)	22600	18500	300	300	3500	4500	2500	161	117	29878	25000
Га-ийн ургац (цн-ээр)	12.0	12.0	12.0	10.0	12.0	8.0	20.0	120.1	119.9		
Хураан авах ургац (тн-аар)	27060	22200	360	300	4200	3600	5000	1934	1403		

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албаны 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01/68 тоот албан бичгийн хүрээнд 2020 онд тарих үрийн буудайн захиалга, нөөцийн судалгааг тариалангийн аж ахуйн нэгж тус бүрээр гарган хүргүүлэв. Үүнд: Халхгол, Баянтүмэн, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Чойбалсан сумдад үр тарианы 18 аж ахуйн нэгж, 1 иргэн 23,8 мянган га-д улаан буудай тариалахаар төлөвлөсөн бөгөөд 2612 тн үрийн нөөцийг бүрдүүлж, 1108 тн дутагдах үрийг ТЭДС-гаас олгох нөхцөлөөр авах саналыг хүрүүлсэн.

## **ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**Хүнсний бүтээгдэхүүний үнэ:** 2020 оны 01 сарын 28-ны өдрөөс 2020 оны 03 дугаар 31-ны өдрийг хүртэл хүнсний 19 нэр төрлийн бүтээгдэхүүний үнийг 8 цэгээс авч 7 хоног бүрийн Лхагва гарагт ЗДТГ-т хүргүүлж ажилласан.

Хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгаа: Хүнсний бараа бүтээгдэхүүний үйлдвэр, худалдаан дахь үлдэгдлийн судалгаа, нөөцийн мэдээ болон гамшгийн үеийн 100 хоногийн хүнсний бүтээгдэхүүний судалгааг 14 сумаас авч орон нутгийн хүн амын тоонд харьцуулан гаргаж 7 хоног бүрийн баасан гарагт ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах зорилгоор хорио цээрийн дэглэм тогтоосон үед хүн амыг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр хангах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн судалгааг 14 сумаас авч нэгтгэлээ.

Тамхины зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг 14 сумаас авч нэгтгэн АЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2020 оны 172 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан аймгийн хүн амын “Гамшигийн үеийн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн”-ийг тооцож гаргаж байна.

## **ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор Сум хөгжүүлэх сан, Хас, ЖДҮХС 2016-2019 онд олгосон нийт зээлийн судалгааг гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлийн авлагын мэдээг 13 сумаар гаргаж, ХХААХҮЯ-ны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.

Шинэ төрлийн коронавирусийн улмаас үүсч болох эрсдлийг тооцож, амны хаалт үйлдвэрлэх боломжтой оёдолчдын судалгааг 14 сумаар гаргаж, аймгийн онцгой комисст хүргүүлсэн.

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний албаны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, BEST төслийн ажилтанд хүргүүлсэн.

Арьс, шир, түүхий эдийн үнэ ханшийн мэдээг 7 хоног бүрийн пүрэв гарагт ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.

## **МАЛ ЭМНЭЛЭГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн хэмжээнд халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд давхардсан тоогоор 8,3 сая толгой малыг хамруулах төлөвлөгөөтэй байна. **Үүнд:**

- Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 6,5 сая толгой мэдрэмтгий мал сүрэг
- Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 554,5 мянган толгой хурга
- Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 886,3 мянган толгой төл мал
- Зооноз халдварт бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 576,7 мянган толгой зөвхөн охин төл мал
- Мал эмнэлгийн халдваргүйтгэлийг 200,000 м<sup>2</sup> талбайд хийж гүйцэтгэнэ.

### **Мал эмнэлгийн үйл ажиллагааны дотоод хяналт:**

МЭЕГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 118 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 2020 оны А/122 дугаар захирамжийн хэрэгжилтийг орон нутагт шалгах, хяналт тавих илэрч буй зөрчил дутагдлыг газар дээр арилгуулах зорилгын хүрээнд МЭЕГ-ын 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар удирдамжаар Баян-Уул, Сэргэлэн, Цагаан-овоо сумдын Мал эмнэлгийн тасгийн 2020 оны төлөвлөлт, дээрх сумдын 23 малчин өрхийн эрүүл мэндийн дэвтэрт 2019 онд гоц халдварт, халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлт, өвчний оношлогоо шинжилгээ, түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуйн баталгаажуулалт хийгдсэн эсэхэд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

2020 оны орон нутгийн халдварт өвчний урьдчилгаа болох 42 сая төгрөгийн санхүүжилтийг хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд шилжүүлэн ажилласан.

### **Мал, амьтны халдварт өвчний гаралт, бүртгэгдсэн байдал:**

Матад сумын 1 дүгээр багийн “Төмөр замын хоолой” гэх газар нутаглах малчин Ж.Лхамсүрэнгийн суурьт 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдөр боом өвчний шинж тэмдэг илэрч, сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/24 дүгээр захирамжаар “Хязгаарлалтын дэглэм” тогтоож, аймгийн МЭАЦЛ-ийн шинжилгээний дүнгээр боом өвчин илрээгүй тул сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар “Хязгаарлалтын дэглэм”-ийг цуцалсан.

Булган сумын 3 дугаар багийн нутаг “Баруун хавцал” гэх газар нутаглах малчин Ш.Гантулгын суурьт 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдөр 1 толгой үхэр боом өвчний шинж тэмдэг илэрч, сумын Засаг даргын А/29 дүгээр захирамжаар “Хязгаарлалтын дэглэм” тогтоож, 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдөр шинж тэмдгээр өвчилж хорогдсон үхрийн сэг зэмийг 3\*4 харьцаа нүх ухаж заавар журмын дагуу булж устгаж, 510м<sup>2</sup> талбай бүхий малын хашаа хороог ариутган халдваргүйжүүлж, 107 толгой үхэрт эрүүл мэндийн үзлэг хийж өвчнөөс сэргийлэх вакцинд хамруулж ажилласан. Аймгийн МЭАЦЛ-ийн 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 20-35 дугаартай шинжилгээний дүнгээр боом өвчин илрээгүй, дахин нэмэгдэж мал өвчлөөгүй тул сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/25 дүгээр захирамжаар “Хязгаарлалтын дэглэм”-ийг цуцалсан.

Халхгол сумын Цогтсүмбэр багийн Баялаг хорооллын голд галзуу өвчний шинж тэмдэг илэрсэн 1 золбин нохойноос дээж авч шинжилгээнд хамруулахад МЭАЦЛ-ийн 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 20-33 дугаартай шинжилгээний дүнгээр “Мал, амьтны халдварт галзуу” өвчнөөр өвчилсөн болох нь тогтоогдсон тул сумын Засаг даргын 2020 оны А/29, 32 дугаар захирамжуудаар “Хязгаарлалтын дэглэм тогтоон” өвчинтэй тэмцэх арга хэмжээ зааврын дагуу явагдаж өвчилсөн нохойтой харьцсан Цогтсүмбэр, Ялалт багийн нутаг дэвсэр дэхь Баянхошуу, Бага Баянхошуу, Баялаг гэх газруудын байршилд 77 нохойг зориудын аргаар буудаж устгаж устгалын цэгт булж устган халдваргүйжүүлж, сумын хэмжээнд 74 айл өрхөд галзуу өвчнөөс сэргийлэх сэрэмжлүүлэг анхааруулга өгч ажилласан. Өвчлөл гарсан бүс нутагт дахин нэмэгдэж зэрлэг ан амьтан, нохойны өвчлөл гараагүй тул сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/36, 37 дугаар захирамжуудаар “Хязгаарлалтын дэглэм”-ийг цуцалсан.

Баянтүмэн сумын 4 дүгээр багийн “Нуга” гэх газар нутаглах малчин Б.Сумъяагийн суурьт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр 2 үхэрт дуут өвчний шинж тэмдэг илэрч, аймгийн МЭАЦЛ-ийн 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 20-37 дугаартай шинжилгээний дүнгээр “Дуут хавдар” өвчин оношлогдсон тул сумын Засаг даргын 2020 оны А/28 дугаар захирамжаар тухайн бүс нутагт “Хязгаарлалтын дэглэм” тогтоон өвчинтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Өвчлөл гарсан бүс нутгийн 5 км радиус дахь 6 өрхийн 556 үхэрт эрүүл мэндийн үзлэг хийж, дуут хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулж, үхсэн 2 толгой үхрийн сэг зэмийг шатааж, булж устган халдваргүйжүүлэн ажилласан. Өвчний бүсэд дахин нэмэгдэж малын өвчлөл гараагүй тул, мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг, эцсийн халдваргүйтгэл хийж сумын Засаг даргын 2020 оны А/31 дүгээр захирамжаар “Хязгаарлалтын дэглэм”-ийг цуцалсан.

Матад сумын 5-р багийн нутаг “Даамай” гэх газар нутаглах малчин Х.Үнэнчулууны суурьт 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр 1 толгой үхрийн шүлс гоожиж, гэдэс татаж, хэл улайж, биеийн халуун 39-40 градустай байгаа талаар

заставын малын их эмч Эрхэмбаяр дуудлага өгсөн. Дуудлагын дагуу Мал, амьтны эрүүл мэндийн албыг хуралдуулж үүссэн нөхцөл байдлыг танилцуулан 03 дугаар сарын 12-ны өдөр МЭАЦЛ-ийн эрхлэгч Э.Түвшинбаяраар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилон газар дээр нь ажиллаж 4 үхрийг ялган тусгаарлан шинжилгээнд шаардагдах дээжийг авч ажилласан.

Авсан дээжинд хийсэн аймгийн МЭАЦЛ-ийн 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 20-38 дугаартай шинжилгээний дүнгээр Мал, амьтны халдварт "Галзуу" өвчин болох тогтоогдсон тул сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/30 дугаар захирамжаар "Хязгаарлалтын дэглэм тогтоосон. Өвчинтэй тэмцэх арга хэмжээ 15 хоногтоо үргэлжилж байна.

### **Халдваргүй өвчний талаар:**

Аймгийн хэмжээнд 2020 он гарсаар халдваргүй өвчин 3 сумын 10 багийн 34 малчин өрхийн өвчилсөн-85, хорогдсон-30, эдгэрсэн-55 үхэрт эмчлэн сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Бодис солилцооны хямралын өвчнөөс эмчлэн сэргийлэх үйлчилгээтэй "Буферфос" бэлдмэлийг УМЭАЦТЛ-с 60 литрийг захиалж өвчлөл илрээд байгаа Сэргэлэн, Булган, Хэрлэн, Баянтүмэн, Хөлөнбуйр сумдад 45 литрийг хуваарилаад байна.

**Ариутгал халдваргүйжүүлэлт:** Мал эмнэлгийн газрын даргын батласан малын гоц халдварт өвчний болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийн хүрээнд Хэрлэн суманд үхрийн фермийн үйл ажиллагаа эрхэлдэг 6 өрхийн 1130м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан.

### **Бусад ажлын талаар:**

Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга Т.Тунгалаг 14 сумын албан хаагчидтай онлайн хурал, сургалтыг 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж албан хаагчдад мэдээ, мэдээлэл өгч ажилласан.

"Дорнод мал эмнэлэг" байгууллагын албан ёсны хуудсанд 03 дугаар сард дотоод ажил, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн авч хэрэгжүүлсэн ажлын талаарх 8 мэдээллийг олон нийтэд хүргэж ажилласан.

Мал эмнэлгийн ерөнхий газраас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын дагуу газрын албан хаагчдыг өндөржүүлсэн бэлэн байдлын үед хариуцлагатай жижүүр хийх хуваарийг боловсруулж албан хаагчдыг 08 цагаас 17 цагийн хооронд хийж гүйцэтгүүлж, МЭЕГ-ын хариуцлагатай жижүүрт цаг үеийн байдлаар мэдээлэл өгч ажиллаж байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган 2019 оны гүйцэтгэлийн гэрээнд тусгагдсаны дагуу дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:

"Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль", Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоол, "Баталгаажуулалтын шинжээчийн дүрэм батлах тухай" Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны А/99 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус хэлтсийн баталгаажуулалтын шинжээч шаардлага хангасан 9 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн, худалдаа үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж орон тооны бус Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

Хурлаар 9 аж ахуйн нэгжийн 9 худалдаа, үйлчилгээний газар хамрагдаж, нийт 9 худалдаа, үйлчилгээний газруудад тохирлын гэрчилгээ олгосон

Үйлчилгээ			
д/д	Нэр төрөл	Тоо хэмжээ	тайлбар
1	Хүнсний дэлгүүр	8	3 дугаар хурал
2	Хүнсний агуулах	2	-
3	Баар	1	-
	<b>Нийт</b>	<b>11</b>	

Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн				
д/д	Нэр төрөл	Иргэн, аж ахуй йнэгж	Тоо хэмжээ	тайлбар
1	Жигнэмэл, чанамал бүтээгдэхүүн	1	1	3 дугаар хурал
2	Хэрчсэн гурил	1	1	
3	Бууз, банш	1	1	
	<b>Нийт 2 Аж ахуй нэгжийн 5 бүтээгдэхүүн</b>			

- Экспортын бүтээгдэхүүн

д/д	Нэр төрөл	Тохирлын гэрчилгээ олгосон тоо	тайлбар
1	Хар тугалганы баяжмал	37	Шинь шинь ХХК
2	Цайрын баяжмал	60	
3	нийт	<b>97 тохирлын гэрчилгээ олгосон</b>	

Стандарт борлуулалт

д/д	Стандартын төрөл	ААН	Иргэн
1	MNS	6	-
2	ISO	1	-
5	нийт	10 ширхэг стандартаар үйлчилсэн	

- Хэмжил зүйн лаборатори:

## Цахилгаан

д/д	Цахилгааны хэмжил	1 фаз	3 фаз
1	Цахилгаан тоолуур	-	
2	нийт		-

## Механик, даралт, температур

д/д	Цулын хэмжил	Тоо ширхэг
1	Электрон жин 40 кг-аасдээш	1
2	Электрон жин 30 кг-хүртэл	20
3	Манометр	-
4	Эмнэлгийн механик жин	-
5	Эмнэлгийн жин	-
6	Авто пүү	2
7	Даралтын аппарат механик	-
8	Үнэт эдлэлийн жин	-
	<b>Нийт</b>	<b>23 ширхэг баталгаажуулсан</b>

## Эзлэхүүн зарцуулалт

д/д	Хэмжих хэрэгслийн нэр	Хаяг	Тоо /ш/
1	Шатахуун түгээгүүр	Хэрлэн сум НИК	6
2	Лабораторийн шилэн хэмжүүр	Хэрлэн сум МХГ	22
3	Усны тоолуур	Хэрлэн сум айл өрх	10
4	Нийт	<b>38 ширхэг баталгаажуулсан</b>	

